

Архангай аймгийн хүн амын шилжих хөдөлгөөнд хийсэн судалгаа

А. Амарбал

Монгол Улсын Их Сургууль,

Хүн Ам Зүйн Сургалт Судалгаааны Төв,

эрдэм шинжилгээний ажилтан

Улсын Статистикийн газрын мэдээнээс авч үзвэл Архангай нутаг дэвсгэр (55.3 кв.км) хүн амын нягтшилтын хувьд 1995 оны байдлаар 1.87 хүн нэг кв.кмт оногдож байгаа нь улсын дунджаас (1.45) илүү нягтшилтай байна.

Хүснэгт 1 Архангай аймгийн хүн амын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	1991	1992	1993	1994
Хүн амын дундаж тоо (мян. хүн)	90.6	92.8	98.5	102.8
Төрсөн хүүхэд	3112	3126	2392	2714
Нас барсан хүн	800	848	835	722
Хүн амын цэвэр өсөлт	2312	2278	1557	1992

(Улсын Статистикийн 1994 оны эмхэтгэлээс)

Хүснэгт 2 Хүн амын шилжих хөдөлгөөн , шилжилтийн хувь				
	1969 -1979		1979 -1989	
	Шилжин ирсэн	Шилжсэн Коэф	Шилжин ирсэн	Шилжсэн Коэф
Аймаг, хот	явсны зөрүү		явсны зөрүү	
Архангай	-18286	-24,4	-16604	-20,49
Баян-Өлгий	-9413	-14,54	-7632	-9,41
Баянхонгор	-7007	-12,15	-9176	-13,34
Булган	-6688	-16,8	-3011	-6,4
Говь-Алтай	-8347	-16,16	-10360	17,47
Дорноговь	788	2,17	426	0,87
Дорнод	3402	7,1	372	0,57
Дундговь	-1667	-4,79	-2721	-6,17
Завхан	-14653	-19,45	-15411	-18,3
Өвөрхангай	-7618	-10,21	-12465	-13,94
Өмнөговь	-1781	-6,01	-1151	-3,05
Сүхбаатар	-4074	-10,39	-7465	-15,88
Сэлэнгэ	8034	15,34	-525	-0,7
Төв	-2495	-3,51	-5308	-5,9
Увс	-10713	-16,19	-12097	-15,54
Ховд	-11279	-19,36	-9260	-13,35
Хөвсгөл	-8180	-10,02	-11904	-12,53
Хэнтий	-331	-0,72	1448	2,37
Дархан-Уул	16633	52,96	17826	28,87
Улаанбаатар	40974	12,73	28166	6,19
Орхон	14537	184,36	18619	60,41
Говьсүмбэр	*	*	*	*

Монгол Улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөн эмхэтгэлээс 1993

Архангай аймгийн шилжих хөдөлгөөний хувьд өмнөх 3 тооллогын хооронд хамгийн их шилжин явалттай аймаг байсныг хүснэгт 2 –оос үзүүлэлтээс харж болно. Хэд хэдэн шалтгаан байсан. Үүнд :

- Хүн амын нягтшал ихтэй
 - Хөдөлмөрийн нөөц илүүдэлтэй гэдгээр зохион байгуулалттай шилжүүлэн нүүлгэлтэнд ихээр хамрагддаг байсан.
 - Үйлдвэрлэл муу хөгжсөн. (Олборлох үйлдвэр байхгүй)
- гэх мэт.

Өмнө гарсан үзүүлэлтүүдээс үзэхэд Архангай аймгийн хүн амын шилжилт гадагш шилжин явалт харьцангуй их байгаа нь статистикийн мэдээллээс харагдлаа. Гэвч Статистикийн газраас гарч буй мэдээллээс нарийвчлан шинжилгээ хийх боломж муутайгаас ИБМ-ийн ХААТР-24 маягтыг ашиглан Архангай аймгаас шилжих хөдөлгөөний талаар таамаглал дэвшүүлж судаллаа.

ХААТР-24 маягтын үзүүлэлтүүдээс авч үзэхдээ

1. Нас

0-15

16-30

31-45

46- дээш

2. Хүйс

3. Шалтгаан

1. Ажлын байртай болсон

2. Дагалдан шилжсэн

3. Ар гэрийн гарчигдал

4. Бусад

4. Боловсрол

1. Боловсролгүй

2. Бага боловсролтой

3. Бүрэн бус дунд

4. Тусгай дунд

5. Бүрэн дунд

6. Дээд

гэсэн ангиллаар бүртгэж шинжилгээ хийсэн.

Насны бүлгийн хувьд бусад орнуудад хийгдэж байсан судалгаануудын үр дүнгүүдтэй төсөөтэй 16-30, 0-15 насны бүлгийн хүн амын шилжилт их байна. Үүнийг гаргасан үзүүлэлтийг он бүрээр авч үзвэл 1991 онд, тухайн нийт шилжин явагчдын 53.85 хувийг 16-30 насны бүлгийн хүмүүс эзэлж байхад 1995 оны байдлаар 40.32 хувь болон буурах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 3

16-30 нас	1991	1992	1993	1994	1995
эрэгтэй	101	145	128	147	256
эмэгтэй	96	158	151	223	227
Тухайн онд эзлэх хувь	53.85	46.98	52.74	54.98	40.32

Энэ насны бүлгийг хүйсийн хувьд хослуулан авч үзэхэд эмэгтэйчүүдийн шилжилт нь 25.08 хувь харин эрэгтэйчүүдийнх 22.79 хувь байгаа нь анхаарал татсан ба таван жилийн хугацаанд нийт шилжин явагчдын 51.31 хувийг мөн л эмэгтэйчүүд эзэлж байгаа нь манайд эмэгтэйчүүд шилжих хөдөлгөөнд илүү оролцдог гэсэн таамаглалд хүргэсэн. Үүний шалтгаан нь миний бодлоор манайд эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийг бодвол илүү байгаагаар холбоотой болов уу.

Тэгвэл дээрх үзүүлэлтийг шилжин явсан шалтгаантай холбож үзвэл ажлын байртай гэсэн категорит бараг ялгаагүй эрэгтэйчүүд 13.76 , эмэгтэйчүүд 13.52 хувийг эзэлж байна. Дагалдан шилжсэн шалтгааны хувьд эрэгтэйчүүд 4.96 эмэгтэйчүүд 9.24 хувийг эзэлж байна. Харин Статистикийн ХА-2 маягтаас энэ

үзүүлэлтүүдийг гаргаж харьцуулалт хийх боломжгүй юм. Учир нь УСГ-ын маягтаар хүйсийн мэдээлэл авдаггүй. Мөн энэ насны бүлгийн хувьд, УСГ-мэдээлэлд хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн нас хэтрэгсэд, хүүхэд гэсэн ангиллаар гаргадгаас шалтгаалан харьцангуй шилжилт ихтэй насны бүлэг шилжилт багатай насны бүлэгтэй хамт байдгаас дүгнэлт өгөхөд бэрхшээлтэй.

Насны хувьд илүү шилжилт ихтэй байдаг 0-16 насны бүлгийг авч үзвэл 1991-1995 онууд нийт шилжигчдийн 25.37 хувийг эзэлж байгаа бөгөөд 100 хувь даган шилжих шалтгаантай байсан. Учир нь ИБМ-д бүртгэхдээ 16 хүрээгүй тохиолдолд ХААТР -24 маягтанд бүртгэхдээ дагалан шилжигчээр бүртгэдэгтэй холбоотой. Энэ насны бүлгийн шилжилтэнд эмэгтэй хүүхдийн шилжилт их байснаас эмэгтэйчүүдийн шилжилт их гарахад нөлөөлсөн байж болох талтай юм. Учир нь 1991-1995 онуудын хооронд бүх онд эмэгтэй хүүхдийн шилжилт их байгаа нь ажиглагдсан. Мөн үүнд нөлөөлж буй хүчин зүйл хүйсийн харьцаа ч байж болно.

Үүний дараа 46-аас дээш насны шилжигчдийг авч үзье. Таван оны хувьд 9.74 хувийг эзэл байсан бөгөөд шалтгааны хувьд 43.86 хувь нь асран хамгаалуулах шалтгаанаар шилжих хөдөлгөөнд оролцсон байна. Мөн энэ насны бүлгийг боловсролтой нь холбож үзвэл 18 хувь нь боловсролгүй гэсэн ангилалд багтаж байсан. Ер нь энэ насны бүлгийн хүмүүс шилжих хөдөлгөөнд өмнөх насны бүлгийг бодвол нутаг орон, хамаатан садангаа түших шалтгаан давамгайлан шилжилтэнд оролцдог нь бусад судлаачдын судалгаагаар харагдаж байсан. Энэ насны бүлгийн шилжилтийн хувьд тухайн орон нутагт амьдрагсадад уугуул төрсөн нутагтаа амьдрагсдын эзлэх хувийн жин нөлөөтэй байж болох таамаглал байдаг. Харин Архангай аймгийн хүн амын сүүлийн тооллогоор (1989) гарсан мэдээллээс үзвэл 96 хувь нь төрсөн нутагтаа амьдарч байгаа гэсэн байдаг. Аймаг доторх шилжилтийн хувьд мөн сумаар нь энэ насны бүлгийн шилжилт ямар байгаа анхаарч дотоод шилжих хөдөлгөөнөө зохицуулах нь зүйтэй.

31-45 насны бүлгийн хүмүүс нь харьцангуй тогтвор суурьшилттай байдаг нь мөн Архангай аймагт хийсэн судалгаанд харагдсан. 1991 нээс 1995 онд нийт шилжигчдийн 17.9 хувь, шалтгааны хувьд ажлийн байртай болсон (23.98 хувь), ар гэрийн гачигдлаар шилжсэн (23.29 хувь), бусад (22.41 хувь) гэсэн үзүүлэлтүүдэд бараг ижилхэн байсан. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийнх (9.94 хувь) эмэгтэйчүүдийнхээс (7.07 хувь) өндөр байгаа нь ганцхан энэ насны бүлэг дээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү шилжилттэй гэж гарсан.

Одоо боловсролоор авч үзье.

Огт боловсрол эзэмшээгүй гэсэн бүлэг нийт шилжигчдийн 23 хувийг эзэлж байгаа боловч үүнийг хүүхдийн шилжилтээс салгаж үзвэл 16 наснаас дээш насны шилжигчдийн хувьд 5 хувь нь огт боловсролгүй гэсэн ба насны бүлгээр үзвэл 46-аас дээш насныхан илүү байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 4

	эрэгтэй	эмэгтэй
0-16	8.57	10.27
16-30	0.29	0
31-45	0	0.12
46-дээш	1	3.23
бүгд (хувиар)	9.86	13.61

Он бүрээр үзвэл ихсэх хандлага ажиглагдсан боловч энэ нь нийт шилжигчдийн шилжилт ихэснээс болсон нь он бүрийн нийт шилжигчдийн хувийн жингээс харагдаж байна.

Хүснэгт 5 Боловсролын түвшингөөр нийт шилжигчдийг харуулбал
1991-1995 (ХААТР- 24) маягтаас

	1	2	3	4	5	6
эрэгтэй	9.86	6.01	10.30	3.52	13.96	5.05
эмэгтэй	13.61	5.28	9.27	6.86	11.59	4.66
бүгд (хувиар)	23.47	11.29	19.57	10.38	25.55	9.71

Боловсролын түвшин дээшлэхэд шилжих хөдөлгөөнд оролцох нь ихэсдэг хандлага энэ судалгаагаар мөн ажиглагдсан. Боловсролын түвшингээр шилжигчдийг он бүрээр авч үзвэл 1994 онд бүрэн дунд боловсролтой хүмүүсийн шилжилт тухайн оны нийт шилжигчдийн 31.2 хувийг эзэлж харин дээд болон тусгай дунд боловсролтой шилжигчдийнх өмнөх онуудаасаа огцом буурснаа 1995 онд бусад онуудынхтай эзлэх хувийн жингээрээ төсөөтэй болсон.

Үүний шалтгаан нь бүртгэлтийн хувьд учир дутагдалтай гэж үзсэн. Учир нь ямар акт баримтийг үндэслэн ажлын байртай гэсэн шалтгаанаар шилжүүлж байгаа нь анхаарал татсан. Жиш : Хэн нэг шилжигч хотод суухын тулд таньдаг хүнээсээ манай албан байгууллагад ажилладаг гэсэн тодорхойлолт гаргуулахад хангалтай юм шиг санагдсан. Иймээс ч энэ шалтгаан бусдаасаа их гарах үндэс болж өгч байна. Шалтгааныг УСГ-ынхтай харьцуулах боломжгүй.

Дүгнэлт

Архангай аймгийн хүн амын шилжих хөдөлгөөний мэдээллээс шилжин явагчдийн дунд хийсэн судалгаанаасаа үзэхэд хүн амын насны бүлгийн хувьд онцлог ажиглагдсангүй харин хүйс боловсролын хувьд цаашид анхаарч үзэх шаардлагатай юм. Учир нь тухайн аймагт өөрийн дотоодод авч явуулж буй бодлогын талаар сонирхож үзэхэд шилжих хөдөлгөөний талаар онцлон анхаарсан зүйл ажиглагдаагүй юм.

Шилжих хөдөлгөөн нь шууд бус замаар нийгэм эдийн засгийн бүхий л асуудалтай холбогдож байдаг. Тухайн бүс нутгийн гадагш шилжилт их байна гэдэг нь нэг талаас ажлын байр дутагдалтай мөн амьдрах нөхцөл байдал хүнд нөгөө талаас өмнө явуулж байсан бодлогын үр дүнгээс шалтгаалан шилжилт бий болсноор дотооддоо нөхцөл байдал сайжрах тохиолдол ч байдаг. Миний бодлоор Архангай аймгийн хувьд дээр дурьдсан боломжийг харж байгаа юм шиг санагдсан. Тэгвэл энэ нь тэр болгон ашигтай үр дүнд хүрдэггүй харин ч ажиллах хүчний дутагдал (боловсон хүчний), хүйсийн харьцаа алдагдах үр дүнд хүргэдэг.

Манай улсын хувьд хот руу шилжих шилжилт нийтлэг байгааг үгүйсгэж болохгүй, харин үүнийг орон нутгийн түвшинд хэрхэн зөв зохицуулж болох эрхийг Монгол Улсын Засгийн Газрын 1996 оны 3 дугаар сарын 4 ний өдрийн дугаар 47 тоот тогтоолын хавсралт журмаар олгосон.

Санал :

1. Бүртгэлийг сайжруулж, боломжтой тохиолдолд мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөөний үндсэн дээр судалгаа явуулж өмнөх мэдээлэл хир бодит байдалд нийцэж байгааг харьцуулах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн учир нь авч явуулах арга хэмжээ үнэн мэдээтэй байж сая зөв үр дүнг өгнө. Шилжих хөдөлгөөний талаар гаргадаг мэдээллүүд (ИБМТ, УСГ, АЗДТГ) нь хоорондоо харьцангуй их зөрөөтэй байна.

2. Гадагшаа шилжилтийг хэрхэн хязгаарлах вэ? гэдэгт анхаарал хандуулалгүй харин эдийн засгийн ямар арга замаар хүн ам тогтортой суурьшуулах, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг нь хэрхэн ямар аргаар сайжруулах, үүнтэй хамт бүсийн хөгжлийг дээшүүлэхэд санаа тавих шаардлагатай.

3. Гаднаас ирж байгаа болон өөрийн нутгийн шинэ залуу боловсон хүчнүүдэд эхний ээлжинд эдийн засгийн тодорхой нэг хөнгөлөлтүүдийг олгох, үүний эх үүсвэрийг дараа дараагийн үед үлдэх хуримтлал маягийн санг эхний ээлжинд өөрийн зардалд тусган гаргаж болно.

4. Орон нутгийн нөхцөлд тулгуурлан ажиллах хүчнийхээ байршилтийг дотоодоо зохицуулах.

5. Аливаа хөдөлгөөнийг нь хязгаарлах бодлого нь эргээд таатай биш үр дүнд хүргэдгийг анхаарах хэрэгтэй.

Ашигласан материал

Архангай аймгийн ХААТР-24

"Монголын хүн амын шилжих хөдөлгөөн" 1973 он О. Сүхбаатар

"State Policies and Internal Migration" A.S. Oberai

"Why people move" Jorge Balan Unesco Press